

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны ..... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.9.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 06 дугаар тогтоолд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

1. Тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ” хэсэгт:

- 1.1. Жагсаалтын 328 дугаарт 51164302 код бүхий оношийн хамааралтай бүлэгт D13, D18 олон улсын өвчний код, 42.3, 43.4, 50.2, 50.3 олон улсын үйлдлийн код, 553 дугаарт 51240011 код бүхий оношийн хамааралтай бүлэгт 96.71, 01.10 олон улсын үйлдлийн код, 560-565 дугаар бүхий оношийн хамааралтай бүлгүүдэд Z03 олон улсын өвчний өвчний кодыг тус тус нэмэх;
- 1.2. Жагсаалтын 554 дугаарт 51240012 код бүхий оношийн хамааралтай бүлгээс 96.71 олон улсын үйлдлийн кодыг хасах;
- 1.3. Жагсаалтын 593 дугаарт буй 51300047 код бүхий оношийн хамааралтай бүлгийн “Эмгэг судлалын шинжилгээ” гэсэн нэрийг “Зарим өндөр өртөгт оношилгоо, шинжилгээ болон эмгэг судлалын шинжилгээ” гэж өөрчлөх;

2. Тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, санхүүжүүлэх журам” хэсэгт:

- 2.1. Удирдамжийн амбулаторийн цогц тусламжийн санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалтад “Амбулаторийн цогц тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ийн жишиг төлбөрийн хэмжээгээр тооцоолох бөгөөд тус тушаалын төлбөрийн

хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр нэмэгдүүлэн тооцох бөгөөд хэрэв тухайн жилд төлбөрийн хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд инфляцитай уялдуудан нэмэгдүүлэн тооцоолж болно.” гэж нэмэх;

- 2.2. Удирдамжийн амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний 1.2.1-т “71” гэснийг 50, 1.2.2, 1.2.3, 1.2.4- т 70 гэснийг 50 болгон өөрчлөх;
  - 2.3. Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын бусад зохицуулалтын 4-ийн “Г” заалтаас “мэс заслын тусламж, үйлчилгээ” гэснийг хасах;
  - 2.4. Амбулаториор хийгдэх оношилгоо, ажилбарын бусад зохицуулалтад “Монгол Улсад хийгддэг, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар 45,000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй хүртээмж бага шинжилгээнүүдийг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлан санхүүжүүлэх ба шинжилгээг бусад тусламж, үйлчилгээтэй давхардуулан санхүүжүүлэхгүй байх” гэж нэмэх;
  - 2.5. Удирдамжийн эрчимт эмчилгээний 4 дэх заалтын хүснэгтийн 7 дахь мөр хэсэгт байгаа “зохиомол амьсгал г.м “ гэснийг хасах
  - 2.6. Журмын эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүргийн 7.1.1 дахь заалтад 4.5.1 гэснийг 4.6.1, 4.5.2 гэснийг 4.6.2, 7.1.2, 7.1.3 дахь заалтад 4.5.3 гэснийг 4.6.2 гэж өөрчлөх,
  - 2.7. Журмын 5.2 дахь заалтын 51300044 гэснийг 51300046 болгож өөрчлөх
3. Тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”,
- 3.1. Журмын 2.6 дугаар заалтыг бүхэлд нь хасах;
  - 3.2. Журмын 2.7 дахь заалтыг “Хорт хавдрын дараах химийн бай эмчилгээнд шаардагдах эм, тариаг тухайн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлж буй эмнэлгүүдэд багцаар нь олгож хяналт тавьж санхүүжүүлнэ.” гэж өөрчлөх;
  - 3.3. Журмын 5.6. дахь заалтыг “Төлбөрийг нь төр хариуцах эм”-ийг санхүүжүүлэхдээ тухайн эмийн нэгдсэн худалдан авалтын үнийг баримталах бөгөөд нэгдсэн худалдан авалтын үнийн дүн дээр урамшуулалын мөнгөн дүн нэмэгдүүлж санхүүжүүлэх ба хэрэв тухайн эм нь нэгдсэн худалдан авалтад багтаагүй тохиолдолд эрүүл мэндийн даатгалын байгууллага нь нэгжийн үнийг зах зээлийн үнэд суурилан тогтооно.” гэж өөрчлөн найруулах;
  - 3.4. Журмын “5.10. хэсэгт \*тэмдэглээ бүхий тусгайлан оруулсан дархлаа эмчилгээний эмийн багцыг олон улсын гэрээ хэлэлцээрт заасан эрүүл мэндийн байгууллага болон төлбөрийн хэмжээг баримтлан баримтлан санхүүжүүлэх бөгөөд хөтөлбөр болон гэрээ дуусах үед санхүүжүүлтийг зогсоох бөгөөд төсөвт тусгасан тохиолдолд санхүүжүүлнэ.” гэж нэмж тусгах;
4. Тавдугаар хавсралтаар баталсан “Төрөөс төлбөрийг нь хариуцах зарим өвчин эмгэг, түүний эмийн жагсаалт, хэлбэр, тун”-д
- 4.1. Жагсаалтын 75 дугаар бүхий Иринотекан, 87 дугаар бүхий Этопозид эмийг хасах;
  - 4.2. Хорт хавдрын бай эмчилгээний эмийн ангилалд Сорафениб шахмал 200мг, Палбоциклиб бүрхүүлтэй шахмал 75мг, 100мг, 125мг, Сүрьеэ өвчний эмийн ангилалд Пиразинамид шахмал 150мг, 400мг эмийг нэмэх;

- 4.3. Жагсаалтын Цочмог промиелоцитын лейкеми, Архаг лимфолейкеми лимфомууд, Архаг миелопролифератив эмгэгүүд өвчний ангилал дахь 94 дугаар бүхий Нилотиниб, 97 дугаар бүхий Ритуксимаб, 98 дугаар бүхий Руксолитиниб эмийг хасаж, шилжүүлэх;
- 4.4. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах байдал ангилал дахь 114 дугаар бүхий Эверолимус шахмал эмээс 5мг, 10мг, 2,5 мг тунгуудыг Хорт хавдрын бай эмчилгээний эмийн ангилал руу хасаж шилжүүлэх;